



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/019/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegi@audit.gov.mn
Аудитор: Т.Баасанцэнд
Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn
Аудитор: Г.Тэлмүүн
Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.АЛТАН-ОД ТАНАА

2025.03.25 № 07/1192
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 1,009,485.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Өмнөх 2021-2023 оны аудитаар сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй 10,666,942.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй;
- Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй, тайлант онд үйл ажиллагаагаа явуулсан 31 аж ахуй нэгжтэй 113,719.2 мянган төгрөгийн авлага, 115 аж ахуй нэгжийн 410,166.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Монгол шуудан ХК-ийн тайлант оны татварын дараах цэвэр ашгаас санд 59,031.4 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй;
- Тайлант оны эцэст 2-5 жилийн насжилттай 308,981.2 мянган төгрөг, 5-с дээш жилийн насжилттай 117,587.8 мянган төгрөг, нийт 426,569.0 мянган төгрөгийн

Z:\Yawsan_Bichig\2025\0325 SNAG-9.Docx

1525071050

авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулах боломжгүй, найдваргүй авлага болох эрсдэлтэй байна.

Дээр дурдсан зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.6, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.5, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмын 3 дугаар зүйлийн 3.2, 3.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 5, 8, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 5 дугаар зүйлийн 5.1-т заасантай тус тус нийцээгүй бөгөөд толилуулга, эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төслийн хүрээнд бий болсон 17 нэрийн, нийт 1,213,339.9 мянган төгрөгийн балансын үнэ, 226,540.9 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 622 дугаар тогтоолоор “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨААТҮГ-д хүлээлгэн өгсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сангийн хөрөнгөөр зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээ хүрээгүй алслагдсан 55 багийн хүн амд үйлчилгээг хүргэх зорилгоор “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-тай 7,695,100.0 мянган төгрөгийн 2 жилийн хугацаатайгаар гэрээ байгуулж, тайлант онд 2,518,397.9 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон байна.

Бусад асуудал

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,453,548,011.33	29,855,012,829.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,153,669,160.87	18,608,731,487.74
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,153,669,160.87	18,608,731,487.74
31210	Төгрөг	15,153,669,160.87	18,608,731,487.74
31211	Төрийн сангийн харилцах	15,153,669,160.87	18,608,731,487.74
33	АВЛАГА	644,772,524.71	579,338,975.10
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	643,306,998.28	579,338,975.10
33500	Бусад авлага	1,465,526.43	-
33510	Байгууллагаас авах авлага	1,465,526.43	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10,655,106,325.75	10,666,942,366.75
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	10,655,106,325.75	10,666,942,366.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,111,967.04	4,070,783.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,111,967.04	4,070,783.28
39200	Биет хөрөнгө	8,111,967.04	4,070,783.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,500,000.00	9,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,166,666.68)	(6,333,333.36)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	9,572,100.00	7,175,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,793,466.28)	(6,271,083.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,859,164.00	-
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,859,164.00)	-
39300	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	2,631,750.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,631,750.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	26,461,659,978.37	29,859,083,612.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,657,124,650.87	3,085,788,529.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,657,124,650.87	3,085,788,29.10
41300	Өглөг	459,172,519.84	747,644,734.44
41360	Бусад өглөг	459,172,519.84	747,644,734.44
41361	Байгууллагад төлөх өглөг	459,172,519.84	747,644,734.44
41400	Урьдчилж орсон орлого	4,197,952,131.03	2,338,143,794.66
41440	Бусад урьдчилж орсон орлого	4,197,952,131.03	2,338,143,794.66
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	21,804,535,327.50	26,773,295,083.77
51	Засгийн газрын хувь оролцоо	21,804,535,327.50	26,773,295,083.77
51100	Засгийн газрын оруулсан капитал	23,293,144.00	23,293,144.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	23,293,144.00	23,293,144.00
51200	Хуримтлагдсан үр дүн	21,781,242,183.50	26,750,001,939.77
51210	Өмнөх үеийн үр дүн	18,997,649,617.61	21,781,242,183.50
51220	Тайлант үеийн үр дүн	2,783,592,565.89	4,968,759,756.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	26,461,659,978.37	29,859,083,612.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,771,394,736.59	9,803,511,091.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,771,394,736.59	9,803,511,091.03
120	Нийтлэг татварын бус орлого	6,771,394,736.59	9,803,511,091.03
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,771,394,736.59	9,803,511,091.03
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,771,394,736.59	9,803,511,091.03
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,641,190.70	3,621,411,375.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,641,190.70	3,621,411,375.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,641,190.70	3,621,411,375.76
2104	Хангамж, бараа материалын зардал	4,653,500.00	1,312,300.00
210401	Бичиг хэрэг	1,792,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,312,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	861,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,797,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,797,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	709,828.00	3,616,057,892.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,615,397,892.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	269,828.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	660,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,480,862.70	4,041,183.76
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,480,862.70	4,041,183.76
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,758,753,545.89	6,182,099,715.27
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,975,160,980.00	1,213,339,959.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,975,160,980.00	1,213,339,959.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,783,592,565.89	4,968,759,756.27
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,212,402,588.93	8,297,608,518.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,212,402,588.93	8,297,608,518.87
120	Нийтлэг татварын бус орлого	9,212,402,588.93	8,297,608,518.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,154,047,708.93	8,009,136,304.27
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,154,047,708.93	8,009,136,304.27
120009	Бусад орлого	58,354,880.00	288,472,214.60
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,022,743,871.00	4,842,546,192.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,022,743,871.00	4,842,546,192.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,022,743,871.00	4,842,546,192.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,792,500.00	1,312,300.00
210401	Бичиг хэрэг	1,792,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,312,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,797,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,797,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,017,154,371.00	4,841,233,892.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,016,444,543.00	4,840,573,892.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	269,828.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	660,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,189,658,717.93	3,455,062,326.87
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	8,189,658,717.93	3,455,062,326.87
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,964,010,442.94	15,153,669,160.87
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,153,669,160.87	18,608,731,487.74

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,293,144.00	-	19,046,374,450.03	19,069,667,594.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(48,724,832.42)	(48,724,832.42)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,293,144.00	-	18,997,649,617.61	19,020,942,761.61
Тайлант үеийн үр дүн	-	-	2,783,592,565.89	2,783,592,565.89
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,293,144.00	-	21,781,242,183.50	21,804,535,327.50
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,293,144.00	-	21,781,242,183.50	21,804,535,327.50
Тайлант үеийн үр дүн	-	-	4,968,759,756.27	4,968,759,756.27
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,293,144.00	-	26,750,001,939.77	26,773,295,083.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,165,542,200.00	4,842,546,192.00	322,996,008.00	93.75
УРСГАЛ ЗАРДАЛ	5,165,542,200.00	4,842,546,192.00	322,996,008.00	93.75
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,159,042,200.00	4,842,546,192.00	316,496,008.00	93.87
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,876,800.00	-	175,876,800.00	-
Нэмэгдэл	152,644,800.00	-	152,644,800.00	-
Унаа хоолны хөнгөлөлт	23,232,000.00	-	23,232,000.00	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,984,600.00	-	21,984,600.00	-
Тэтгэврийн даатгал	14,949,500.00	-	14,949,500.00	-
Тэтгэмжийн даатгал	1,758,800.00	-	1,758,800.00	-
ҮОМШӨ-ний даатгал	879,400.00	-	879,400.00	-
Ажилгүйдлийн даатгал	879,400.00	-	879,400.00	-
Эрүүл мэндийн даатгал	3,517,500.00	-	3,517,500.00	-
Хангамж, бараа материалын зардал	17,460,000.00	1,312,300.00	16,147,700.00	7.52
Бичиг хэрэг	2,560,000.00	-	2,560,000.00	-
Тээвэр, шатахуун	9,500,000.00	-	9,500,000.00	-
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,600,000.00	1,312,300.00	1,287,700.00	50.47

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,800,000.00	-	2,800,000.00	-
Эд хогшил, урсгал засварын зардал	9,500,000.00	-	9,500,000.00	-
Багаж, техник, хэрэгсэл	9,500,000.00	-	9,500,000.00	-
Томилолт, зочны зардал	21,602,800.00	-	21,602,800.00	-
Дотоод албан томилолт	20,345,500.00	-	20,345,500.00	-
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,257,300.00	-	1,257,300.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,911,118,000.00	4,841,233,892.00	69,884,108.00	98.58
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,908,200,000.00	4,840,573,892.00	67,626,108.00	98.62
Даатгалын үйлчилгээ	198,000.00	-	198,000.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	-	198,000.00	-
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-	22,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,500,000.00	660,000.00	1,840,000.00	26.40
Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	-	1,500,000.00	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	-	1,500,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,500,000.00	-	6,500,000.00	-
Бусад урсгал шилжүүлэг	6,500,000.00	-	6,500,000.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,500,000.00	-	6,500,000.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,165,542,200.00	8,009,136,304.27	(2,843,594,104.27)	155.05
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,165,542,200.00	8,009,136,304.27	(2,843,594,104.27)	155.05
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,165,542,200.00	8,009,136,304.27	(2,843,594,104.27)	155.05
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,790,119,595.57	14,790,119,595.57	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	17,956,709,707.84	17,956,709,707.84	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 6,442,857.9 мянган төгрөгийн 6 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сангийн хөрөнгөөр алслагдсан бүсэд сүлжээ оруулах ажлын хүрээнд бий болсон, санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэлд бүртгэлтэй 6,442,857.9 мянган төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийг үйлчилгээ авсан гэж үзэж төслийн хэрэгжих хугацаа дууссан үед ашиглагч байгууллагад эрх бүхий байгууллагын тушаал, шийдвэрээр шилжүүлээгүй, шууд зардлаар бүртгэсэн байна.	1	6,442,857.9	1	6,442,857.9			1	6,442,857.9				
Дүн	1	6,442,857.9	1	6,442,857.9			1	6,442,857.9				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

3.2 Аудитаар нийт 1,009,485.9 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 59,031.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 950,454.4 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй Монгол шуудан ХК-ийн тайлант оны татварын дараах цэвэр ашгаас 3 хувийг тооцож, санд 59,031.4 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна.	1	59,031.5	1	59,031.5							
Тайлант онд үүссэн 115 аж ахуй нэгжийн 410,166.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	1	410,166.2			1	410,166.2					
Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй, тайлант онд үйл ажиллагаагаа явуулсан 31 аж ахуй нэгжтэй 113,719.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	1	113,719.2			1	113,719.2					
Тайлант оны эцэст 2-5 жилийн насжилттай 308,981.2 мянган төгрөг, 5-	1	426,569.0			1	426,569.0					

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

с дээш жилийн насжилттай 117,587.8 мянган төгрөг, нийт 426,569.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах боломжгүй, найдваргүй авлага болох эрсдэлтэй байна.										
Өмнөх 2021-2023 оны аудитаар сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй 10,666,942.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.	1	-			1	-				
Нийт дүн	5	1,009,485.9	1	59,031.5	4	950,454.4	-	-	-	-